

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: **Давтамж хувиргагч**  
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202112010**

**“Монголросцветмет” ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос **Давтамж хувиргагч** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2018, 2019 онуудын аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байх ба харилцагч банкнаас тодорхойлолт авах тохиолдолд уг тендерт ялсан тохиолдолд зээл олгох боломжтой байна гэсэн утга бүхий банкны тодорхойлолтыг шаардлага хангасан материал гэж үзнэ.**

Тендерийн хамт нийт **1,340,000** /нэг сая гурван зуун дөчин мянга/ төгрөгийн дүн бүхий тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 10:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 504 тоот өрөө, утас: 450060 + 152

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**